

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/02

Чойр

Цодгор хүү-2019 тэмцээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах Цодгор хүү-2019 тэмцээний удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.
2. Цодгор хүү-2019 тэмцээнийг зохион байгуулах ажлыг Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн /Э.Урантунгалаг/-д даалгасугай.
3. Тэмцээнд зарцуулагдах 375.000 /гурван зуун далан таван мянга/ төгрөгийг холбогдох дансны зардлаас гаргахыг нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНБИЛЭГ